



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/19

Хажуу шинэ ус

Газар эзэмшүүлэх эрхийг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 1.1 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 2021 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/111 тоот захирамжийг хүчингүй болгож, 2-р дугаар багийн иргэн П. Мөнхөөгийн Бомбухайн Сондуул, 1-р багийн иргэн Г. Амар-Амгалангийн Дөрвөлжингийн энгэр, 3-р багийн иргэн Б. Ууганбаярын Сувдан хонд, 1-р багийн иргэн М. Мөнгөндуулгийн Сүүл толгойн зүүн зэрэг 4 иргэний газрын гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Хоёр: Иргэний газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хураан авч хүчингүй болгохыг газрын даамал (Б. Хорол)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН